



МОНГОЛ ГАЗРЫН ТОС
БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР ТӨХХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД

**МОНГОЛ УЛСЫН УУЛ УУРХАЙ,
ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас: 32-63-67, Факс: (976-11) 31-13-81,
<http://www.mmhi.gov.mn>

2020.02.07 № 01/358

танай _____-ны № _____-т.

**Засгийн газрын тогтоолын
төсөл хүргүүлэх тухай**

Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 08-ний өдрийн “Шинэ нисэх онгоцны буудлын шатахуун хангамжийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 14 дугаар тогтоол гарсан.

Энэ тогтоолоор танай компанийн үйл ажиллагааг өргөжүүлж, шинэ нисэх онгоцны буудлын шатахуун хангамжтай холбоотой үйл ажиллагаа эрхлэх охин компани байгуулахыг даалгасан.

Иймд холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг ханган, охин компани байгуулах асуудлыг яаралтай зохион байгуулж ажиллана уу.

Хувийг Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-д
Хавсралт 1. хуудастай.



Д.СУМЪЯАБАЗАР

08 0114



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 1 дүгээр
сарын 8-ны өдөр

Дугаар 14


Улаанбаатар
хот

Шинэ нисэх онгоцны буудлын шатахуун
хангамжийн талаар авах зарим
арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 6-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Монгол газрын тос боловсруулах үйлдвэр" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үйл ажиллагааг өргөжүүлж, шинэ нисэх онгоцны буудлын шатахуун хангамжтай холбоотой үйл ажиллагаа эрхлэх зорилгоор охин компани байгуулах арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолын 1 дэх заалтад заасан охин компанийг байгуулах, түүнд хөрөнгө оруулах, бүтээгдэхүүн нийлүүлэх сонирхол илэрхийлсэн гадаадын хөрөнгө оруулагчтай хэлэлцээр хийх ажлыг зохион байгуулж, дүнг 2020 оны I улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Уул уурхай, хүнд
үйлдвэрийн сайд

У.ХҮРЭЛСҮХ

Д.СУМЪЯАБАЗАР